



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналын дагуу  
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

## **МИАТ ХК–д нийлүүлж буй шатах тослох материалын тендер шалгаруулалтын үр дүн, үр нөлөө**



## **Үнэлгээний хороо толгой компанийг охин компанитай нь өрсөлдүүлэн тендерт шалгаруулжээ**

# АГУУЛГА

## Тайланг бэлтгэсэн:

### ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын захирал: Д.Ганбилэг

Шинжээч: Д.Баттулга

2010 оны 3 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын:

Веб сайтаас үзнэ үү.  
[www.mnao.mn](http://www.mnao.mn)

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал 261675  
дугаарын утас, 323266  
дугаарын факс,  
[battulgad@mnao.mn](mailto:battulgad@mnao.mn)-ээр  
харилцана уу

## **ХАЯГ:**

Үндэсний аудитын газар  
Чингэлтэй дүүрэг,  
Засгийн газрын 4 дүгээр  
байр,  
Бага тойруу-6,  
Улаанбаатар-46  
Монгол Улс

Товчилсон үгсийн жагсаалт.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
<b>Бүлэг 1: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна</b>	
• Ерөнхий зүйл .....	5
• Худалдан авах журмыг баримтлаагүй байна .....	6
• Гэрээний зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.....	7
<b>Бүлэг 2: Роснефть компани зөвхөн нэг импортлогчоор дамжуулан шатахуун нийлүүлэх болсон, өнөөгийн байдлаар шатахуун сумлах ганц станц байгаа нь шударга өрсөлдөөний нөхцөл бүрдэх боломжийг хязгаарлаж байна</b>	
• “Сод монгол групп” ХХК онгоцны түлш импортлох давуу эрх эдэлж байна.....	8
• Онгоцны шатахууны дотоодын зах зээлийн үнэ өндөр байгаагаас МИАТ ХК гадаадаас онгоцны далавчинд шатахуун сумлах үйлчилгээ авч байна.....	9
• МИАТ ХК-иар үйлчлүүлж буй зорчигчийн тийзийн үнийг бусад авиа компаниас хямд байлгахын тулд холбогдох арга хэмжээ авч байна.....	10
Дүгнэлт: .....	11
Холбогдох байгууллагын санал.....	12
Зөвлөмж:.....	13

## **ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ**

<b>УИХ</b>	<b>Улсын Их хурал</b>
<b>ҮАГ</b>	<b>Үндэсний аудитын газар</b>
<b>ИНЕГ</b>	<b>Иргэний нисэхийн ерөнхий газар</b>
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	<b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль</b>
<b>ЗТБХБ</b>	<b>Зам тээвэр, барилга, хот байгуулалт</b>
<b>ТӨХ</b>	<b>Төрийн өмчийн хороо</b>
<b>ЭБЭХЯ</b>	<b>Эрдэс баялаг, эрчим хүчний яам</b>
<b>ТЕГ</b>	<b>Татварын ерөнхий газар</b>

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### ***Аудитын зорилт***

МИАТ ХК-д нийлүүлж буй шатах тослох материалын тендер шалгаруулалтын үр дүн, үр нөлөөг шалгаж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- *Шатах тослох материалыг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;*
- *Онгоцны тийзийн үнэ өсөхөд шатахууны үнэ нөлөөлж буй эсэх;*

### ***Хамарсан хүрээ***

Аудитаар МИАТ ХК-д 2009 онд нийлүүлсэн шатах, тослох материалын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийг хөрөнгийн дүн, түүний зарцуулалт, гүйцэтгэлийн тайлан, дансны журнал, анхан шатны баримтууд, зарим судалгаа, мэдээлэл, холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

### ***Арга зүй***

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав.

Аудитын тайланд төлөвлөлтийн шатанд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, илрүүлсэн зүйлс, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, судалгаанаас гадна холбогдох байгууллагын саналыг тусгав.


## Бүлэг 1

**Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна**

### Ерөнхий зүйл

1.1. МИАТ ХК олон улсын болон орон нутгийн агаарын шугамд зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж нислэг, техникийн аюулгүй ажиллагаа, зорчигчийн тав тухтай байдлыг бүрэн хангах, Бээжин, Сөүл, Хөх хот, Токио, Осака, Москва, Берлин, Эрхүүгийн чиглэлд “Кореан эйр”, “Эйр чайна”, “Аэрофлот” зэрэг гадаадын авиа компаниудтай өрсөлдөн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байна.

1.2. МИАТ ХК 2009 онд 95579.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн 93894.1 сая төгрөгийн зардал гаргаж 1589,6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Орлого зардлын зүйл ангийг диаграмаар харуулбал:



1.3. МИАТ ХК-ийн 2009 оны нийт орлогын 82 хувь нь зорчигч тээвэрлэлтээс, 8 хувь нь ачаа тээвэрлэлтээс оржээ. Харин нийт зардлын 24 хувь нь шатахуун болон шатах тослох материалд, 29 хувь нь агаарын хөлгийн түрээсийн зардал болон шууд бус зардалд, 34 хувийг төрөл бүрийн хураамжууд болон шууд зардал эзэлж байна.



1.4. Гадаад нислэгийн зорчигчийн тоо, түүний өсөлт бууралтыг 2007-2009 оноор харуулбал:

1.5. МИАТ ХК 2009 оны байдлаар түрээсийн 2 Боинг-737-800, өөрийн эзэмшлийн Аэробус-310-300 маркийн онгоцуудаар 239.3 мянган зорчигч

тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 13.6 хувиар буурсан байна.

## **Худалдан авах журмыг баримтлаагүй байна**

1.6. МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар ТБОНӨХБАУХАТХуулийн (цаашид “тендерийн хууль” гэх) дагуу үнэлгээний хороог гурван хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Харин үнэлгээний хорооны нарийн бичгийн даргыг ажлын байрны тодорхойлолтоор орон тооны албан тушаал болгон, санал өгөх эрхгүйгээр гүйцэтгүүлэх болсон нь үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байна гэж заасан журмыг зөрчсөн<sup>1</sup> байна.

1.7. 2008 онд онгоцны ТС-1 маркийн шатахуун нийлүүлэх тендерийг нээлттэй хэлбэрээр зарлах байтал өрсөлдөөнийг хязгаарлан “Ойн бирж” ХХК, “Сод монгол групп” ХХК, “Алхана трейд” ХХК (Сод монгол групп ХХК-ийн охин компани) гэсэн гурван компаниас үнийн санал авахаар болсон байна.

1.8. Гэвч “Ойн бирж” ХХК тодорхой бус шалтгаанаар тендерийн материал ирүүлээгүй, “Алхана трейд” ХХК болон “Сод монгол групп” ХХК-ийн ирүүлсэн тендерийн баримт нь ижил төрлийн бөгөөд үнэлгээний хороо тендерийн баримтыг хянан үзэж, үнэн зөв сонгон шалгаруулж чадаагүй байна.

1.9. Тендер шалгаруулалтад оролцсон “Алхана трейд” ХХК тендер үнэлэх нийт найман шалгуурын ганц үзүүлэлтээс бусдыг хангаагүй байна.

1.10. 2009 онд онгоцны ТС-1 шатахуун нийлүүлэх компани сонгон шалгаруулах нээлттэй тендерийг тухайн оны 4 дүгээр сарын 17-нд өдөр тутмын сонинуудаар зарлаж, тендерийн баримт бичгийг “Петровис” ХХК, “Жаст ойл” ХХК, “Магнай трейд” ХХК, “Петрожамп” ХХК зэрэг компаниуд худалдан авсан байна.

1.11. 2009 оны 5 дугаар сарын 18-нд тендерийн нээлт хийхэд дээрх компаниуд холбогдох бичиг баримтыг ирүүлээгүй учир үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг хүчингүй болгожээ.

1.12. Тендерийн үнэлгээний хороо 2009 оны 10 дугаар сарын 13-ны өдөр дахин тендер зарласан боловч 10 дугаар сарын 29-ний өдөр Үнэлгээний хорооны даргын 03/2213 дугаар албан бичгээр тендерийн урилгыг тодорхой шалтгаангүйгээр хүчингүй болгосон байна.

1.13. МИАТ ХК орон нутгийн зуны нислэгийн хэрэгцээнд зориулан 2009 оны 6 дугаар сарын 22-нд ТС-1 шатахуун нийлүүлэх санал авахдаа өрсөлдөөнийг хязгаарлан “Магнай трейд” ХХК, “А-Жет Лимитед” ХХК, “Сод монгол групп” ХХК-иудаас үнийн санал авч “Магнай трейд” ХХК-ийг шалгаруулсан нь “худалдан авах ажиллагааны журмын харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг”<sup>2</sup> зөрчсөн байна.

1.14. Тендерт оролцоогүй “Магнай трейд” ХХК-ийн охин компани “МТ Петролиум” ХХК-тай МИАТ ХК гэрээ байгуулан 121711 ам,долларын 137 тонн онгоцны ТС-1 шатахуун худалдан авчээ.

<sup>1</sup> Худалдан авах ажиллагааны журмын 47.2 үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байна

<sup>2</sup> Худалдан авах ажиллагааны журмын 8.1.1 харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

### ***Гэрээний зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна***

- 1.15. “Сод монгол групп” ХХК онгоцны ТС-1 шатахуун худалдах болон худалдан авах тухай гэрээний 3.1<sup>3</sup> заалтыг зөрчсөн нь тухайн компани агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх тусгай тоног төхөөрөмж байхгүйтэй холбоотой байна.
- 1.16. МИАТ ХК-д нийлүүлэх шатахууны тендерт оролцсон “Сод монгол групп” ХХК нь “А-Жет Лимитед” ХХК-тай агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ байгуулсан байна.

---

<sup>3</sup> Бэлтгэн нийлүүлэгч нь шатахууныг худалдан авагчийн Буянт –Ухаа дахь “Чингис Хаан” ОУНБ-ын перронд байгаа агаарын хөлөгт хүргэнэ

## Бүлэг 2

*Роснефть компани зөвхөн нэг импортлогчоор дамжуулан шатахуун нийлүүлэх болсон, өнөөгийн байдлаар шатахуун сумлах ганц станц байгаа нь шударга өрсөлдөөний нөхцөл бүрдэх боломжийг хязгаарлаж байна*

2.1. “Роснефть” компаниас “Сод монгол групп” ХХК-д онгоцны түлш импортлох давуу эрх олгосон тухай Газрын тосны газарт ирүүлсэн СБ-431 дугаар бичгийг үндэслэн МИАТ ХК-ийн тендерийн үнэлгээний хороо 2009 онд зарласан тендерийг хүчингүй болгож тухайн компанитай шууд гэрээ байгуулжээ.

2.2. Гэвч “Сод монгол групп” ХХК Роснефть компанийн худалдсан ТС-1 шатахууныг хилийн үнийн тонн тутамд зах зээлийн үнээс хамааруулан 40-45 ам. долларын шимтгэл<sup>4</sup> нэмж “А-Жет лимитед” ХХК-д “ДАФ-Наушка”<sup>5</sup> нөхцөлтэйгээр нийлүүлж байжээ.

2.3. Харин “А-Жет лимитед” ХХК гаалийн бүрдүүлэлт хийн, тээвэрлэх, хадгалах сумлах зэрэг үйлчилгээ үзүүлж МИАТ ХК-тай шатахууны болон үйлчилгээний төлбөрийн тооцоо хийж байна.

2.4. Дэд бүтцийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 261 дүгээр тушаалын Хавсралт-7-оор батлагдсан “Нисэхийн хангамжийн байгууллагыг гэрчилгээжүүлэх дүрэм”-ийг баримтлан ИНЕГазраас S3 ангиллын гэрчилгээг “А-Жет лимитед” ХХК-д олгожээ.

2.5. Энэ нь агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээг орон нутагт ИНЕГ, Улаанбаатар хотод “А-Жет лимитед” ХХК давамгайл байдлаар үзүүлж байна.

2.6. МИАТ ХК нь “Сод монгол групп” ХХК болон “А-Жет лимитед” ХХК-иудтай нэг ижил гэрээ байгуулсан ба гэрээний биелэлтийг дүгнэж баримтжуулаагүй байна.

2.7. “Сод монгол групп” болон “А-Жет лимитед” ХХК-иуд онгоцны шатахуун импортлох болон цэнэглэх давуу эрхээ ашиглан шатахууны үнийг өндөр байлгах замаар МИАТ ХК-ий ашигт сөргөөр нөлөөлөх нөхцлийг бий болгож байна.

**Онгоцны шатахууны дотоодын зах зээлийн үнэ өндөр байгаагаас МИАТ ХК гадаадаас онгоцны далавчинд шатахуун сумлах үйлчилгээ түлхүү авч байна**

<sup>4</sup> Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шалгалтын дүн

<sup>5</sup> Хил дээрээс худалдаж авах үйл ажиллагаа



2.8. 2009 онд МИАТ ХК онгоцны ТС-1 шатахуун худалдан авахад 22608,9 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 28,7 хувиар буурсан байна. ТС-1 шатахууны гадаад дотоод худалдан авалтыг сүүлийн гурван оноор харьцуулан харуулбал:



2.9. МИАТ ХК 2009 онд дотоодын зах зээлээс буюу “А-Жет лимитед” ХХК-иас 8097,7 сая, гадаад нислэгийн үер 14511,3 сая төгрөгийн ТС-1 шатахуун худалдан авчээ.

2.10. МИАТ ХК болон “А-Жет лимитед” ХХК-ийн хооронд ГОСТ № 10227-86 стандартын шаардлага хангасан шатахуун нийлүүлэх гэрээ байгуулсан ба стандарт техникийн нөхцөл бүрдсэн шатахуун нийлүүлж иржээ.

Хүснэгт № 1

/тонн/ам.долл/

Сарууд	2008 он		2009 он	
	Хилийн үнэ	МИАТ ХК-ийн худалдан авч буй үнэ	Хилийн үнэ	МИАТ ХК-ийн худалдан авч буй үнэ
1	894	1143	572	1550
2	894	1143	637	1150
3	894	1143	637	950
4	1061	1355	716	950
5	1132	1445	666	950
6	1181	1506	693	950
7	1369	1726	729	990
8	1480	1851	760	1035
9	1480	1851	820	1074
10	1244	1619		1074
11	1037	1619	793	1074
12	825	1619	816	1074
Дундаж	1124	1502	713	1068

Эх сурвалж: Газрын тосны газрын судалгааг үндэслэв

шатахууны үнийг гэрээний хавсралтаар харуулан үнийн өөрчлөлт орох бүрт баталгаажуулан шинэчлэх бөгөөд сар болгон өөрчлөлт оруулдаг байна.

2.11. Сод монгол групп” ХХК болон “А-Жет лимитед” ХХК-иуд зах зээлийн үнээс өндрөөр шатахуун нийлүүлж, үнэ буурч байсан үед ч өөрчлөлт хийдэггүйгээс МИАТ ХК гадаадаас онгоцны далавчинд шатахуун сумлах үйлчилгээг түлхүү авч байна.

2.12. МИАТ ХК нь “Сод монгол групп” ХХК болон “А-Жет лимитед” ХХК-тай байгуулсан шатахуун худалдан авах гэрээнд

2.13. “А-Жет лимитед” ХХК шатахуун хадгалах савнаас улиралд нэг удаа, сумлагч машинаас сард нэг удаа дээж авч хөндлөнгийн байгууллагаар чанарын шинжилгээ хийлгэн дүгнэлтийг ИНЕГ-ын нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албанд хүргүүлж байна. Түүнчлэн МИАТ ХК-ийн дотоод аудитаас чанарын шинжилгээ хийж хэвшсэн байна.

**МИАТ ХК-уар үйлчлүүлж буй зорчигчийн тийзийн үнийг бусад авиа компаниас хямд байлгахын тулд холбогдох арга хэмжээ авч байна**

2.14. МИАТ ХК зах зээлд өрсөлдөх, онгоцны түлшний үнийг бууруулах зорилгоор шатахуун импортлох, хадгалах савтай болох, онгоц цэнэглэх үйл ажиллагаа эрхлэх талаар ЭБЭХЯ, ТӨХ, ИНЕГ-т тодорхой санал хүргүүлж байжээ.

2.15. МИАТ ХК үр ашиг нэмэгдүүлэх, суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор, зах зээл болон нислэгийн давтамжтай уялдуулан нислэгийн тарифийн олон улсын “ Airfare “ системийг ашиглаж байна.

2.16. Энэ нь зорчигч нислэгээ урьдчилан захиалж хямд үнээр үйлчлүүлэхээс гадна тусгай, түр, урамшуулалт, транзит зэрэг олон төрлийн тариф мөрдөх боломжийг бий болгожээ.



2.17. 2005 онд гүйцэтгэх захирлын Б/201 дүгээр тушаалаар түлшний үнийн өсөлтийг харгалзан зорчигч, ачааны ангиллаар олон улсын бүх чиглэлд терроризмын үйл ажиллагааны эрсдлийн даатгалын (YQ) хураамж, шатахууны үнийн өсөлтийн эрсдлийн (YR) хураамж авч байна.

2.18. 2009 онд МИАТ ХК шатахууны үнийн өсөлтийн эрсдэл (YR) хураамжаар гадаад нислэгийн зорчигчдоос 7,4 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олжээ.

2.19. МИАТ ХК-д нийлүүлж буй онгоцны шатахууны үнэ өндөр байгаа боловч тийзийн үнийг хямдруулах бодлого баримтлан авиа компаниудтай өрсөлдөж байна. Тийзийн үнийг бусад авиа компаниудынхтай харьцуулан харуулбал:

Хүснэгт 2

төгрөгөөр

Дд	Чиглэл	Зэрэглэл	Эйрчайна	Корэйн Эйр	Аэрофлот	МИАТ ХК	Тийзийн үнийн зөрүү
1	Бээжин	Бизнес	1358050			937450	420600
2		Энгийн /үндсэн/	623050			483450	139600
3		Групп	443050			461450	-18400
4	Сөүл	Бизнес		1511750		1348950	162800
5		Энгийн /үндсэн/		813750		756950	56800
6		Групп		736750		724950	11800
7	Москва	Бизнес			2305850	1598250	707600
8		Энгийн /үндсэн/			1053850	996250	57600
9		Групп			922850	894250	28600

2.20. Дээрх судалгаанаас харахад МИАТ ХК-ийн тийзийн үнэ бусад авиа компанийн тийзийн үнээс чиглэл болон зэрэглэлээсээ хамааран 28600-707600 төгрөгөөр хямд байна.

## **ДҮГНЭЛТ**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:**

- **Монгол Улсад импортлож буй онгоцны шатахууны үнэ дэлхийн зах зээлийн үнээс харьцангуй өндөр байна**
- **Онгоцны шатахуун импортлох болон агаарын хөлөг сумлах давуу эрхийг цөөн компани эдэлж байгаагаас шударга өрсөлдөөний зарчим алдагдаж, үнэ нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна**
- **Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, худалдан авах аргыг буруу сонгож, тендерийг үнэн зөв хянаж, сонгон шалгаруулаагүй байна**
- **Гэрээний биелэлтийг хангаагүй, гэрээний заалт биелээгүй байхад хариуцлага тооцоогүй байна**

## Холбогдох байгууллагын санал



### МИАТ ХУВЬЦААТ КОМПАНИ

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45,  
Утас: 37-99-68, Факс: 37-99-19, 37-98-77,  
Site: ULNDDOM, ULNTTOM,  
<http://www.miat.com>


2010.03.17 № 03/689

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газраас МИАТ хувьцаат компанид нийлүүлж буй шатах тослох материалын тендер шалгаруулалтын үр дүн, түүний үр дүнгийн нөлөөллийн асуудлаар хийсэн аудитын тайлан, дүгнэлттэй танилцлаа.

Компанийн зүгээс Үндэсний аудитын газраас ирүүлсэн тайлантай санал нэг байгаа бөгөөд цаашид үйл ажиллагаандаа уг тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН  
ДЭД ЗАХИРАЛ

З.ЭНХБАЯР

## **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**ЗТБХБ-ын сайд Х.Баттулгад:**

- ОХУ-аас онгоцны шатахуун нийлүүлэх давуу эрхийг ганц компанид олгож, шударга өрсөлдөөнийг хязгаарласан асуудлыг хоёр орны Засгийн газар хоорондын комиссын түвшинд хэлэлцэж, зохистойгоор шийдвэрлэх, онгоцны шатахууны үнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Одоо баригдаж байгаа шатахуун сумлах станцыг ашиглалтад оруулахад анхаарах

**Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Д.Мандахад**

- Онгоцны шатахууны нийлүүлэлтэд шударга өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа нөхцөл байдлыг судалж холбогдох арга хэмжээ авах

**ТӨХ-ны дарга Д.Сугарт**

- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй албан тушаалтанд арга хэмжээ авах
- ИНЕГ-аас МИАТ ХК-д шилжүүлсэн шатахуун хадгалах савыг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авах

**ТЕГ-ын дарга Ц.Оюунбаатарт**

- Онгоцны шатахуун нийлүүлж байгаа холбогдох компаниудын татвар төлөлтөд хяналт тавьж байх

**МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Бат-Эрдэнэд**

- Гэрээний биелэлтэд хяналт тавьж, гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээний дагуу хариуцлага тооцож байх
- Шатахууны зах зээлийн үнэд судалгаа хийж, худалдан авалтыг үр ашигтай зохион байгуулж ажиллах



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5 "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. МИАТ ХК-д нийлүүлж буй шатах тослох материалын тендер шалгаруулалтын үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, ЗТБХБ-ын сайд Х.Баттулга, ТЕГ-ын дарга Ц.Оюунбаатар, ТӨХ-ны дарга Д.Сугар, ШӨХТГ-ын дарга Д.Мандах, МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Бат-Эрдэнэ нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2010 оны 10 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг дээр дурдсан албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

*Ч.Раднаа*

Ч.РАДНАА

070082  
tushaal